



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2022/66/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Өмнөговь аймаг
Даланзадгад сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Шижирболд
Утас: 70005329 Цахим хаяг: shijirboldg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

46083, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон 304 тоот
Утас: (976) 7053 3539, Вэб сайт: www.audit.mn
И-мэйл: umnugovi@audit.gov.mn

2022.02.21 № 58
танай _____ -ны № _____ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ш.ОТГОНБАЯР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 С.ЦЭРЭНБАЯР

D:\2021 Он\Бичиг Хэрэг\Явсан Бичиг\2022-02-21 №58"с

013000000

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

| | | /сая төгрөгөөр/ | |
|------------------------------------------------|---------------------------------------------------|-----------------|-----------------|
| | Үзүүлэлт | 2020.12.31 | 2021.12.31 |
| Санхүүгийн байдлын тайлан | | | |
| | Эргэлтийн хөрөнгийн дүн | 5,043.2 | 2,742.3 |
| | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 5,064.5 | 5,044.7 |
| | Нийт хөрөнгийн дүн | 10,107.7 | 7,787.0 |
| | Нийт өр төлбөрийн дүн | 0 | 0 |
| | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 10,107.7 | 7,787.0 |
| | Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 10,107.7 | 7,787.0 |
| Санхүүгийн үр дүнгийн тайлан | | | |
| | Үйл ажиллагааны орлогын дүн | 3,210.4 | 580.8 |
| | Үйл ажиллагааны зардлын дүн | 634.1 | 2,890.7 |
| | Үйл ажиллагааны үр дүн | 2,576.2 | -2,309.8 |
| | Үйл ажиллагааны бус үр дүн | -71.7 | -10.8 |
| | Үйл ажиллагааны нийт үр дүн | 2,504.6 | -2,320.7 |
| Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | | | |
| | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | 10,107.7 |
| | Тайлант оны үр дүн | | -2,320.7 |
| | Эцсийн үлдэгдэл | | 7,787.0 |
| Мөнгөн гүйлгээний тайлан | | | |
| | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн | 491.4 | 295.1 |
| | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн | 351.2 | 293.7 |
| | Үйл ажиллагааны ЦМГ | 140.2 | 1.4 |
| | Хөрөнгө оруулалтын ЦМГ | 0 | -1.4 |
| | Санхүүгийн ажиллагааны ЦМГ | 0 | 0 |
| | Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | 140.2 | 0 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 0 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 0 |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлан | | | |
| | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | | 233.7 |
| | Урсгал зардал | | 233.7 |
| | Хөрөнгийн зардал | | 0 |
| | Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр | | 233.7 |
| | Улс, орон нутгийн төсвөөс санхүүжих | | 223.6 |
| | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | 0 | 10.1 |

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааны зорилго нь " Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх, хөрөнгийн өгөөж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөх тэгш боломжийг хангахад оршино " гэж тодорхойлжээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.



Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Байгууллагын үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 100 ширхэг үндсэн хөрөнгө байна. Эдгээр хөрөнгийг актлах, устгах, зарим ашиглах боломжтой үндсэн хөрөнгөнд үнэ тогтоох шаардлагатай байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан болно.

5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллүүдийг мэдээлсэн байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын цаг хугацаа богино байсан тул бараа материал, үндсэн хөрөнгөд тулган баталгаажуулалт хийгээгүй болно. Иймд дараагийн аудитаар тус байгууллагын бараа материал, үндсэн хөрөнгөд тооллого хийх нь зүйтэй гэж үзлээ.

Долоо. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 30.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 30.5 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлэв.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | | | | |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |



| | | | | | | | | | | | |
|---|------|--|--|--|--|--|--|--|--|--|--|
| 3 | ЗГТС | | | | | | | | | | |
|---|------|--|--|--|--|--|--|--|--|--|--|

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

| д/д | Байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|-----|------------------|----------------------|------|-----------|------|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | ОНӨГазар | 3 | 30.5 | 2 | 30.5 | - | - | - | - | 1 | - |